



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/153

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалт, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Үржлийн малд хянан магадалгаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”-ын 3.3 дахь хэсэг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны А/108 дугаар тушаал, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын байгуулсан үр дүнгийн гэрээний 67 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Өндөршил суманд үржүүлж буй “Нутгийн шилмэл” адуунд явуулсан үржил селекцийн ололтыг хянан магадлах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох орон нутгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
Нарийн бичгийн дарга: Ё.Дашням (Шилийн хурд уяачдын холбооны тэргүүн)

Гишүүд: Т.Цэвэлмаа (Баянжаргалан сумын засаг дарга)  
О.Ганбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)  
Б.Батсүрэн (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)  
Д.Чулуунаа (Мал эмнэлгийн тасгийн их эмч)  
Т.Мөнхбат (1-р багийн Засаг дарга)  
Ч.Үнэнхүү (2-р багийн Засаг дарга)  
М.Цэвэгдорж (3-р багийн Засаг дарга)

Хоёр. Үржил селекцийн ажлын үр дүнд хянан магадалгаа хийх ажлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, ажлын тайланг аймгийн засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

Гурав. Хянан магадалгаа хийхэд шаардагдах зардлыг малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх хэсэгт заасны дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Өндөршил сумын Засаг дарга (Л.Мөнхбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190421